

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тодруулга	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	19
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	19
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	21
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	22
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24

Товчилсон үгийн жагсаалт

ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа Ажил Үйлчилгээ Худалдан Авах Тухай хууль
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.ЭРДЭНЭБАЯР
ТАНАА

2020.03.13 № 06/810
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Эрдэнэбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн дансны авлага, үндсэн хөрөнгө, татварын тайлан, худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 11-нээс 2020 оны 3 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг Аудит ХХК-ийн аудитын менежер Г.Мөнхбаяр, аудитор Н.Мөнхзаяа, аудиторын туслах Б.Данзандорж, Ш.Отгонням нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2019 оны санхүүгийн тайлангаа Мэжик консалтинг Аудит ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/208 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн эрхэм зорилго нь “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг Монгол хүн бүрт дамжуулан хүргэж, улс орныхоо нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх өндөр хурдны хамгийн хүртээмжтэй үндэсний сүлжээ болоход” оршино.

Холбооны сүлжээний төрийн өмчит компани байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 186 дугаар тогтоолын дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг “Суурь болон салбар сүлжээний кабел шугам, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг түшиглэн зөвхөн сүлжээний үйлчилгээ явуулах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль ;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолд орсон өөрчлөлтүүдийг тус тус дагаж мөрдөж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” программ хангамж ашигладаг байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 49,961.2 сая төгрөгөөс тооцон 499.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,745.6 сая төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Б			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,160.0	4,896.4	(263.6)
Авлага	4,272.3	5,087.3	815.1
Бараа материал	3,144.5	3,306.0	161.5
Бусад санхүүгийн хөрөнгө	3,000.0	2,500.0	(500.0)
Урьдчилж төлсөн зардал	3,747.3	507.8	(3,239.5)
Эргэлтийн хөрөнгийн дүн	19,324.1	16,297.6	(3,026.5)
Үндсэн хөрөнгө	89,202.8	134,938.6	45,735.8
Биет бус хөрөнгө	37,425.5	38,372.4	947.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	5,276.6	5,365.9	89.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	131,904.8	178,676.9	46,772.1
Нийт хөрөнгө	151,228.9	194,974.5	43,745.6
Богино хугацаат өр төлбөр	2,847.2	4,022.1	1,175.0
Урт хугацаат өр төлбөр	47,971.0	89,607.9	41,636.8
Нийт өр төлбөр	50,818.2	93,630.0	42,811.8
Төрийн өмч	137,551.5	137,551.5	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,291.5	16,216.1	(75.4)
Эздийн өмчийн бусад хэсэг	41,204.8	42,041.1	836.3
Хуримтлагдсан ашиг	(94,637.1)	(94,464.2)	172.9
Эздийн өмчийн дүн	100,410.7	101,344.5	933.8
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	151,228.9	194,974.5	43,745.6

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үлдэгдэл 263.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралт нь ердийн үйл ажиллагааны явцад бий болсон.

Авлага үлдэгдэл нь өмнөх оныхоос 815.1 сая төгрөгөөр өссөн нь 2019 оны орлогын өсөлттэй холбоотой том харилцагчдын дансны авлагын дүн нь 1,030.9 сая төгрөгөөр өссөн, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь 180.6 сая төгрөгөөр буурснаас тус тус шалтгаалжээ.

Бараа материалын үлдэгдэл нь 161.5 сая төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанаас бий болсон бөгөөд түүхий эд материалын үлдэгдэл 158.8 сая төгрөгөөр буурсан, хангамжийн материалын үлдэгдэл 36.6 сая төгрөгөөр өссөн, түлш шатахууны үлдэгдэл 123.9 сая төгрөгөөр өссөн, ашиглалтад буй материалын үлдэгдэл 175.5 сая төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалжээ.

Бусад санхүүгийн хөрөнгө нь 500.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 3,239.5 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө, бараа материал, ажил гүйцэтгэлийн он дамжсан худалдан авалтын дүнг 2019 онд үндсэн хөрөнгө, бараа материал болон бусад холбогдох зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь өмнөх оныхоос 45,735.8 сая төгрөгөөр өссөн байна. Тайлан хугацаанд шинээр худалдан авсан, бүртгэлд тусгасан 10,488.7 сая, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 123 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2017 оны А-5/3591 тоот албан бичгийн дагуу 46,326.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэж авсан байна.

Мөн ТӨБЗГ-ын 2019 оны 24, А-5/101 тоот тогтоолын дагуу 4,802.0 сая төгрөгийн дансны үнэтэй, 4,705.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг данснаас хассан, шинээр тооцоолсон 10,896.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл зэргээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн өмнөх оныхоос 947.0 сая төгрөгөөр өссөн нь 1,087.2 сая төгрөгийн дүн бүхий түгээх сүлжээний төхөөрөмжийн, өгөгдлийн сүлжээний хяналтын удирдлагын, олон улсын дамжуулах төхөөрөмжийн картын гэх мэт программ хангамжуудыг худалдан авсан, шинээр байгуулсан 140.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл зэргээс шалтгаалжээ.

Бусад эргэлтийн бус хөрөнгийн өсөлт нь 89.3 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгийн тооцооллоос бий болсон байна.

Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт өр төлбөрийн дүн өмнөх оноос 42,811.8 сая төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн өмнө оны дүнгээс 1,175.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд Монгол Улсын Сангийн яам болон Мэдээлэл Холбооны Сүлжээ ХХК-ийн хооронд байгуулагдсан дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн дагуу төлөгдөх богино хугацаат зээлийн өрийн үлдэгдэл 1,406.8 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 626.2 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй, 2019 онд үүссэн худалдан авалтын баталгаа болон барьцаа өр төлбөрийн өсөлт 320.3 сая төгрөг, дансны өглөгийн бууралт 1,453.1 сая төгрөгийн дүн зэрэг нөлөөлжээ.

Урт хугацаат өр төлбөрийн дүн өмнөх оны дүнгээс 41,636.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд бүртгэлд тусгасан 46,305.8 сая төгрөгийн хойшлогдсон орлого, дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн бууралт болох 2,125.2 сая төгрөгийн дүнгээс шалтгаалжээ.

Эздийн өмчийн дүн нь 933.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд тайлант хугацааны хуримтлагдсан ашиг 471.7 сая төгрөг, зарласан ногдол ашиг 374.2 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2019 оны №А-5/551 тоот тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7А хорооллын гадна холбоожилтын 409.4 сая төгрөгийн ажлыг хүлээн авсан, ТӨБЗГ-ын 2019 оны 497 тоот тогтоолоор 36.4 сая төгрөгийн автомашин шилжүүлж бүртгэсэн ажил гүйлгээнүүд нөлөөлсөн байна.

2.9. Зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тодруулга

ТӨБЗГ-ын 2018 оны 603 дугаар тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Орлогын гүйцэтгэл:

Үндсэн сүлжээний борлуулалтын орлого 48,331.1 сая төгрөг, бусад үйл ажиллагааны бус орлого 2,489.7 сая төгрөг, нийт 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар 50,820.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж, гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 12.1 хувиар буюу 5,482.2 сая төгрөгөөр тус өссөн байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн орлогын өсөлтөд тайлант хугацаанд шинээр захиалгат үйлчилгээний орлого 4,267.2 сая төгрөг, улс хоорондын транзит урсгалын орлого 2,356.8 сая төгрөг, байр талбай, антенн түрээсийн орлого 603.3 сая төгрөгөөр өссөн зэрэг нөлөөлсөн байна.

Зардлын гүйцэтгэл:

Тайлант оны гүйцэтгэлээр нийт зардал 50,017.1 сая төгрөг үүнээс удирдлагын зардал 849,9 сая төгрөг байна. Зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 11.2 хувь буюу 5,019.5 сая төгрөгөөр өссөн байна. Зардлын өсөлтөд Зам тээврийн яамтай байгуулсан гурвалсан гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын өртөг, тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн тоног төхөөрөмжийн элэгдлийн зардлын өсөлт, оператор компаниудын орон нутгийн сайтуудад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг үзүүлдэг болсон, мөн сүлжээний өргөтгөл, урсгал нэмсэнтэй холбоотойгоор гадаад урсгалын төлбөр зэрэг байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 281.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 22.8 сая төгрөгийн алдааг залруулж, 258.7 сая алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн. Үүнд:

2019 оны 01 дүгээр сарын 31-нд импортоор оруулж ирсэн 225.7 сая төгрөгийн өртөг бүхий "Huawai board" тоног төхөөрөмжийн гаальд төлсөн 22.8 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг уг тоног төхөөрөмжийн өртөгт шингээгээгүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд хасагдах нэмэгдсэн өртгийн албан татвараар тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5.-д “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг засч дахин гаргаж, татварыг хөрөнгийн өртөгт шингээж залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 258.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монголын цахилгаан холбоо ТӨХК-тай маргаантай байгаа байр талбайн түрээсийн гэрээг шинэчлэх эсэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Монголын Цахилгаан Холбоо ТӨХК-тай тодорхой шийдэлд хүрч ажиллаж байгаа талаар дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 59 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 0.5 сая төгрөгийг барагдуулсан, 131.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 131.8 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс хэрэгжүүлж ажилласан, хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Шилэн дансны тухай хуультай холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 1, 6, 9-р саруудад хоцроож байршуулсан байна.
- Увс аймгийн Өмнөговь сумын холбооны салбарт 20 метр цамхаг барих МХС/201901045-4 тоот худалдан авах ажиллагааны дүнг цахим сайтад 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх.”, 6 дугаар зүйлийн 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.2.1 Илрүүлэлт:

2 харилцагчийн 98.2 сая төгрөгийн гэрээт ажлыг заасан хугацаанд дуусгаж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д захиалагч нь "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах" үүрэгтэй гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны хүрээнд харилцагчтай байгуулсан гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, ажил гүйцэтгэлтэй холбоотой хяналтыг сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ТӨБЗГ-ын 2019 оны №24, А-5/101 тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг актлагдсан үндсэн хөрөнгөд 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг илүү тооцоолсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоололд алдаа гарсан байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг үнэн зөв хийж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Татварын тайлантай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайланг бэлтгэхдээ ТТ-11(1), ТТ-11(2) мэдээнд ажилтны мэдээллийг зөрүүлж тайлагнасан байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/104 тоот тушаал "Маягт, тайлан нөхөх зааварт нэмэлт өөрчлөлт оруулах, мэдээний маягт батлах тухай"-ын хавсралттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Мэдээ тайланг буруу гаргасан байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Татварын тайланг холбогдох байгууллагаас баталсан маягтын дагуу үнэн зөв тайлагнах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Дансны авлагын дэлгэрэнгүй тайланд 34 харилцагчийн 158.4 сая төгрөгийн насжилт өндөртэй авлагууд байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, барагдуулаагүй байх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийн бууруулах, барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Гадаад валютаарх авлагын ажил гүйлгээ, үлдэгдэлд ханшийн тооцооллыг давтан гүйцэтгэхэд 0.4 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. .

Энэ нь НББОУС 21-ийн 29-д “... Ажил гүйлгээ гарч тохиолдсон тухайн нэг ижил нягтлан бодох бүртгэлийн тайлант үед түүний төлбөрийг барагдуулсан тохиолдолд ханшийн бүх зөрүүг уг тайлант үед хүлээн зөвшөөрнө...” гэж заасантай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт мөрдөж ажиллаагүй байх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Гадаад валютын ханшийн тооцооллыг СТОУС-ын дагуу тооцоолж байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,159,973,098.70	4,896,427,938.51
1.1.2	Дансны авлага	3,828,816,443.05	4,818,533,693.40
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	183,209,365.02	2,555,761.19
1.1.4	Бусад авлага	260,243,346.20	266,254,073.09
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,000,000,000.00	2,500,000,000.00
1.1.6	Бараа материал	3,144,523,346.08	3,305,978,048.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,747,334,743.12	507,825,132.78
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	19,324,100,342.17	16,297,574,647.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	89,202,834,893.91	134,938,602,492.61
1.2.2	Биет бус хөрөнгө	37,425,454,461.20	38,372,442,627.65
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	283,658,196.14	372,987,705.84
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,992,898,691.59	4,992,898,691.59
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	131,904,846,242.84	178,676,931,517.69
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	151,228,946,585.01	194,974,506,164.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,397,510,907.15	944,363,844.84
2.1.1.3	Татварын өр	61,450,670.28	316,110,675.83
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	12,960,498.80
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	1,406,848,767.33
2.1.1.6	Хүүний өглөг	-	626,226,544.29
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	15,551,346.58	22,685,112.29
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	372,671,996.07	692,943,667.91
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,847,184,920.08	4,022,139,111.29
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	44,620,755,057.75	42,495,557,212.87
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,904,293,207.50	3,028,328,967.21
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	446,000,000.00	-
2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	44,083,964,733.91
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	47,971,048,265.25	89,607,850,913.99
2.2	Өр төлбөрийн нийт дүн	50,818,233,185.33	93,629,990,025.28

2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,291,526,517.35	16,216,140,727.72
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	41,204,833,121.41	42,041,126,681.79
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(94,637,140,950.62)	(94,464,245,981.59)
2.3.11	Эздийн өмчийн дүн	100,410,713,399.68	101,344,516,139.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	151,228,946,585.01	194,974,506,164.74

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	40,040,380,296.04	48,331,140,853.34
2	Борлуулалтын өртөг	32,881,533,331.90	44,376,134,661.08
3	Нийт ашиг (алдагдал)	7,158,846,964.14	3,955,006,192.26
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	679,792,306.21	401,457,061.29
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	57,960,433.35	2,058,443,103.01
9	Борлуулалт, маркетингийн зардал	337,051,524.59	302,462,103.77
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,112,989,215.21	3,532,713,801.25
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	1,501,199,275.67	1,750,178,406.09
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(10,021,765.78)	(31,137,566.20)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(23,742,666.81)	5,298,596.03
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,911,595,255.64	803,713,075.28
19	Орлогын татварын зардал	862,211,531.68	297,315,073.57
19.1	Хойшлогдсон татварын зардал	(445,166,757.95)	34,706,250.02
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,494,550,481.91	471,691,751.69
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,494,550,481.91	471,691,751.69
23	Бусад дэлгэрэнгүй орлого	15,879,701,121.30	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	15,879,701,121.30	
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	18,374,251,603.21	471,691,751.69

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
					Нийт дүн
2017 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	137,551,494,711.54	413,738,403.33	1,347,724,159.68	(96,075,787,568.15)	43,237,169,706.40
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	7,159,431.28	7,159,431.28
Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	413,738,403.33	1,347,724,159.68	(96,068,628,136.87)	43,244,329,137.68
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	2,494,550,481.91	2,494,550,481.91
Бусад дэлгэрэнгүй орлого	-	15,879,701,121.30	-	(848,363,227.66)	15,031,337,893.64
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	39,857,108,961.73	-	39,857,108,961.73
Зарласан ногдол ашиг	-	-	-	(214,700,068.00)	(214,700,068.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(1,913,007.28)	-	-	(1,913,007.28)
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,291,526,517.35	41,204,833,121.41	(94,637,140,950.62)	100,410,713,399.68
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	16,291,526,517.35	41,204,833,121.41	(94,637,140,950.62)	100,410,713,399.68
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	471,691,751.69	471,695,351.69
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	836,293,560.38	-	836,293,560.38
Зарласан ногдол ашиг	-	-	-	(374,182,572.29)	(374,182,572.29)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(75,385,789.63)	-	75,385,789.63	-
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	137,551,494,711.54	16,216,140,727.72	42,041,126,681.79	(94,935,937,733.28)	101,344,516,139.46

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	43,361,639,266.55	52,128,514,829.74
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	43,220,172,238.10	51,403,219,621.33
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	14,562,002.00	18,537,300.00
	Бусад мөнгөн орлого	126,905,026.45	706,757,908.41
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	35,558,472,876.22	42,328,334,576.50
	Ажиллагчдад төлсөн	11,426,900,217.69	13,544,641,019.95
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,182,884,980.92	4,013,427,290.01
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,954,782,746.27	1,526,560,057.33
	Ашиглалтын зардалд төлсөн	9,516,179,509.26	14,157,705,384.91
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,271,483,735.45	1,925,516,973.65
	Хүүний төлбөрт төлсөн	1,051,941,601.40	377,343,579.37
	Татварын байгууллагад төлсөн	5,745,332,090.06	5,378,811,829.17
	Даатгалын төлбөрт төлсөн	70,070,733.00	45,396,881.91
	Бусад мөнгөн зарлага	1,338,897,262.17	1,358,931,560.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,803,166,390.33	9,800,180,253.24
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	755,288,766.11	432,219,102.37
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	20,066,700.00	16,174,000.00
	Хүлээн авсан хүүны орлого	735,222,066.11	416,045,102.37
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,808,665,160.24	9,401,923,902.67
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,806,165,160.24	9,401,923,902.67
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,500,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,053,376,394.13)	(8,969,704,800.30)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,915,935.50	5,851,957.22
	Бусад	12,915,935.50	5,851,957.22
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,351,421,057.08	1,099,872,570.35
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,125,197,844.88	718,349,077.55
	Төлсөн ногдол ашиг	214,700,068.00	374,182,572.29
	Бусад	11,523,144.20	7,340,920.51
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,338,505,121.58)	(1,094,020,613.13)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,588,715,125.38)	(263,545,160.19)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,748,688,224.08	5,159,973,098.70
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,159,973,098.70	4,896,427,938.51

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020/03/14	Аудитын нэр:	<i>Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит</i>	Аудитын код: САГ-2020/27/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5			9	10
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төндөрийн ерөнхий мэдээллийг 1, 6, 9-р саруудад хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн			Гүйцэтгэх захирал Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр Э.Энхтайван
2	Увс аймгийн Өмнөговь сумын холбооны салбарт 20 метр цамхаг барих МХС/201901045-4 тоот худалдан авах ажиллагааны дүнг цахим сайтад 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй байршуулсан байна.	0.8	Зөвлөмж өгсөн			Гүйцэтгэх захирал Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр Э.Энхтайван
3	Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй 2 харилцагчийн 98.2 сая төгрөгийн гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусгаж ажиллаагүй зөрчил илэрсэн болно.	98.2	Зөвлөмж өгсөн			Гүйцэтгэх захирал Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Ч.Золбаяр Э.Энхтайван
4	ТӨБЗГ-ын 2019 оны №24, А-5/101 тогтоолын дагуу үндсэн хөрөнгийг актлагдсан үндсэн хөрөнгөд 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг илүү тооцоолсон байна.	0.9	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баярсайхан

5	Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайланг бэлтгэхдээ ТТ-11(1), ТТ-11(2) мэдээнд ажилтны мэдээллийг зөрүүлж тайлагнасан байна.	-	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
6	Дансны авлагын дэлгэрэнгүй тайланд 34 харилцагчийн 158.4 сая төгрөгийн насжилт өндөртэй авлагууд байна.	158.4	Зөвлөмж өгөх			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
7	Гадаад валютаарх авлагын ажил гүйлгээ, үлдэгдэлд ханшийн тооцооллыг давтан гүйцэтгэхэд 0.4 сая төгрөгийн зөрүү үүссэн.	0.4	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
8	2019 оны 01 дүгээр сарын 31-нд импортоор оруулж ирсэн 225.7 сая төгрөгийн өртөг бүхий "Huawai board" тоног төхөөрөмжийн гаальд төлсөн 22.8 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг уг тоног төхөөрөмжийн өртөгт шингээгээгүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд хасагдах нэмэгдсэн өртгийн албан татвараар тайлагнасан байна.	22.8	Залруул- га хийх			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
Нийт		281.5					

